

Барын хэмжээ 31 x 5,6 см. , нийт 60 гаруй номын монгол орчуулга бий. Бээ жин бар, УНШС-гийн монгол намын хөмрөгт

⁹ Дарма гүүш. , "sitün barilduvsan maytayal kemegdekü orusiba" Цаасны хэмжээ

39 x8,5 см, Барын хэмжээ 31,4 x 5,6см Хуудасны тоо 7...Бээжин бар, УНШС-гийн монгол номын хөмрөгт

¹⁰ W.Heissig Dei Pekinger Lamaistischen Blockdrucke in mongolischer sprache. WIESBADEN. 1954. NO. 66, p.55-58

¹¹ Данзан-Осор, "gün sitüged barilduju бүтүгсен-i nomlaysan-u egüden-ece maytaysan sayin nomlal-un jerqün kemekü orosibai: : Цаасны хэмжээ 24 x 8,2 см. , Хуудасны тоо 7, Гар бичмэл, Хувийн номын санд

¹² PRATITYASAMUTPADASTUTISUBHASITAHHRDAYAM OF ACARYA TSONK HAPA Translated by Gyalten Namdol, Ngawang Samten, Sarnath. 1982

¹³ rten 'brel bstod pa' sa bcad ldem dgongs kyi gsung 'ga'i don nyams su len tsul bcas mdo hzam bstan pa, x.12., "Kha" буюу 2-р ботийн дотор. , УНШС-гийн төвд хөмрөгт

¹⁴ rten brel bstod pa' i dga gnas las brtzams pa'i don 'grel rin chen phren ba, x. 26. , "Ka" буюу 1-р ботийн дотор., УНШС-гийн төвд номын хөмрөгт

¹⁵ zab mo rten 'byung gsung pa' i 'bstod pa legs bshad snying po'i mchan 'grel, x. II., "Kha" буюу 2-р ботийн дотор., УНШС-гийн төвд номын хөмрөгт

¹⁶ rten brel bstod pa' i bsdus pa, x. 6. , "Nga" буюу 4-р ботийн дотор. , УНШС-гийн төвд номын хөмрөгт

¹⁷ rten 'brel bstod pa i'grel ba tsig:nyung don gsal, x. 15 Дандар арга

¹⁷ rten brel bstod pa' i grel ba tsig nyung don gsal, x. 15 Дандар аграмбын «Ka» буюу 1-р ботийн дотор. , УНШС-гийн төвд номын хөмрөгт

¹⁷ rten 'brel bstod pa'i tikka legs bshad nor bu' i bang mdzod, x. 57., буюу 2-р ботийн дотор., УНШС-гийн төвд номын хөмрөгт

¹⁹ rten 'brel bstod pa legs bshad snying pa' i sa bcad gsai ba i me long x. 10., "Kha" буюу 2-р ботийн дотор. , УНШС-гийн төвд номын хөмрөгт

²⁰ rten 'brel bstod pa' i sa bcad bsdus don rab gsal sning gi me long, x. I., "Ka" буюу 1-р ботийн дотор. , УНШС-гийн төвд номын хөмрөгт

²¹ bstod pa legs shad snying po' i 'grel pa mkhas pa' i yid "phrog, x. 212, "Kha" буюу 2-р ботийн дотор. , Зохиогчийн хувийн номын санд

²² rten brel bstod pa' i grel pa legs shad gsal agron, x, 36 Гар бичмэл, Зохиогчийн хувийн номын санд

²³ rten brel bstod pa'i sa bcad, x. 4. , "Ka" буюу 1-р ботийн дотор. , УНШС-гийн төвд номын хөмрөгт

²⁴ rten "brel bstod pa' i sa bcad, x.I., "Nga" буюу 4-р ботийн дотор, УНШС-гийн төвд номын хөмрөгт

²⁵ bstan pa' i gsal. byed Er-te-ni Mer-gen pandi-ta bla ma'i gsang ba'i nam thar, x. 17. , "Ka" буюу 1-р ботийн дотор "Nga—42 Зохиогчийн хувийн номын санд

**ЗАРИМ ХЯТАД РОМАНЫ
МОНГОЛ ОРЧУУЛГЫН
ТУХАЙД**

Ж. Баттөр

Монгол, хятад хоёр улс, орчлон тэргүүлэшгүй цагаас аваад нутаг савлан оршоор ирсэн үлэмж их түүхт, эртний соёл улсууд билээ. Иймд тус хоёр улсын ард түмний хооронд эдийн болоод оюуны соёлын лут их ялгаа буйн зэрэгцээ Энэтхэг, Төвд, Хятад, Манж, Монголын түүх соёлын хүрээ, ерөөс нийт Азийн соёлын хүрээ гэсэн ойлголтын үүднээс үзвэл олон салбарт нэлээд ойр дөт харилцаатай байж, тэрхүү харилцаа ч үлэмжхэн зүйлд ул мөрөө үлдээжээ..

Хятадууд монголын эртний түүх бичгийн өв сангаас өөрийн хэлнээ орчуулах, галиглан буулгадаг байсны адил («Монголын нууц товчоо» гэх мэт) монголчууд ч мөн, хятадын түүх, утга зохиолын дээжээс цөөн бусыг орчуулсан болой.

Монгол оронд бүр Хятан гүрний (Х зууны үеэс) үеэс эртний хятадын 5 номыг (зурхайт ном, шүлэглэлт ном, засагт ном, шашинт ном, ёслолт ном) орчуулсан байна.

1240 онд Күнзийн суртлын «Да Сыюу Ян-ий» гэдэг номыг Хубилай сэцэн хаан уг зохиогчоор нь орчуулгаж, уг эрдэмтэн «Лунь Юй», «Да Се», «Мунь Юн», «Мэн зи» зэрэг 4 номыг мөн монгол хэлнээ орчуулжээ. Урьд орчуулсан зохиолыг хянан шийтгэх, дахин гарах орчуулгын чанарт нөлөөлсү хэмээж 1264 онд хятадын сонгодог зохиол орчуулах ба түүх зохиох хороог байгуулсан байна. Энэ үеэс «Зи ди дүн жиан ган мү» гэдэг түүхийн нэвтэрхий толь «Төрийн үнэн тэмдэглэл», «Дөрвөн бичиг» зэргийг орчуулсан. 1282 онд Хятадын бичгийн хүн Сы Магуаны зохиосон «Тунзян» гэдэг их түүхийг монгол хэлнээ хөрвүүлж дөрвөлжин болон монгол бичгээр хэвлэн гаргаж байжээ.

Тан улсын үеийн (618—907) хуульзүйн бичиг «Жи Гуаны засгийн товчоон»-ийг Цагаан гэдэг хүн монголчилсон гэдэг мэдээ буй ажээ. Энэ мэт эртний олон орчуулгаас уламжлагдан үлдсэн нь цөөвтөр МЭӨ 200 онд Күнзийн бичсэн «Ачлалт номыг», Булу Төмөр 1307 онд орчуулсныг Лувсанбалдан гуай Бээжингээс авчирч тайлбар сэлттэйгээр хэвлүүлсэн.

Их Юань улсын үе, том хэмжээний туульсийн зохиол, роман төдийлөн гараагүй байсан цаг.

Мин улсын үед (1368— 1644) соёлын харилцаа бараг тасарч, нэг ч роман орчуулагдсангүй.

Их Аригуун улс хэмээх Манж Чин улсын үед (1644 — 1911) монгол, манж, хятадын соёлын хүрээ өргөжиж ялангуяа XIX зууны сүүл XX зууны эхээр «Баруун этгээд зорчсон нь» хэмээх гүн ухааны сэдэвт роман «Гурван улсын бичиг» түүхэн роман, Пү Сүнлинии «Ляо жай жи и бичиг» гэдэг хөөрхөн туурь үлгэрийн зүйл маш сайхан бичиг ярианы үг хосолсон «Эрт эдүгээгийн гайхамшиг сайхан үзэгдэл хэмээх судар» гэдэг «Жинь гу ци гуань», «Жинь Пинь Мэй» гэдэг аж байдлын роман, «Улаан асрын зүүд» гэдэг сэтгэл зүйн роман гээд олон зохиолыг орчуулжээ.

Манж нар 1600-аад оны үед монгол бичгийг авч өөрийн бичиг үсэгтэй болоод хятадын «Гурван улсын түүх»-ийг өөрийн хэлнээ орчуулсан нь даруй том хэмжээний туульсын энэ зохиолын уран сайхны үнэ цэнэд биширсэн төдийгүй, хятадын улс төр, цэрэг, байлдааны урлагийг судлахын тул хийсэн аж. Манж нар мөн Күнзийн суртлын ном бичиг «Жинь Пин Мэй», «12 цамхаг», «Хүйтэн уулын бичиг» тэргүүтэн 33 роман орчуулсан юм.

Монгол хэлнээ хөрвүүлсэн анхны роман нь «Жун дагины бичиг» хэмээх 1703 онд орчуулсан зохиол гэж үздэг. Цаашид энэ зохиолыг олонтаа хуулбарлан янз бүрийн нэрээр тархсан юм. Улсын нийтийн номын сан, Ц. Дамдинсүрэн гуайн хувийн цуглуулгад болон Копенгаген дэх Вангийн нэрт номын санд буй. Дээд эрдэмтний төр барих үес Хан Цэвээнжав манжаас орчуулжээ. Түүнээс янар судар маягаар тархсан нь буддын шашны ламын үзэлт монголчуудад Жун дагины дүр охин тэнгэр Балдан Лхамын хувилсан дүр мэтээр сэтгэгдэн, сонирхлыг асар татаж байсантай холбоотой. Энэ романыг улбаалан судалбаас «Жун у Янь» гэдэг нэртэй урьд хятадад гээгдсэн гэж үзэж байсан роман болох нь нотлогджээ. Энэ мэт академич Б. Ринчен

гуайн өгүүлсэнчлэн хятадын нэлээд зохиол, эх орондоо, эх хэлээрээ алдагдан байсан нь монгол хэлэнд хэдүйн орчуулаастай ажээ.

Олонд ихэд алдаршсан, дараагийн нэг роман бол XVI зууны үед зохиолч У Ченьэнгийн бичсэн «Баруун этгээд зорчсон нь» гэдэг өвөрмөц маягийн зөгнөлт туульсын зохиол болно. Зохиолд сармагчны хаан Сунь Укуны адал, зугаатай явдлыг өгүүлдэг нь монгол хүмүүс Буддын сургаалын нээлт, бодь мөрийн зэргийг олсон мэт үзэж ихэд сонирхон уншдаг байжээ. Орчуулгын эхнээ: Төвдийн залбирлын ум-ма ни-бад-ми-хум мааний талбин бичиж, төгсгөлд ялж төгс нөгчсөн Шагьямуни, Очир зүрхэн бурхан, Лусын хан тэргүүтэн хорт мууг арилган тонилгогч бурхад, тэнгэр нарт мөргөхийг дуудан уриалж, энэ номыг сайтар уншсугай гэжээ.

УННСанд 12 ширхэг, Копенгаген, Японы Тэнрийгийн их сургуулийн номын сан. Будапешт, Стогольмийн номын санд бийгээс гадна түүний Ойрад орчуулга байдаг юм. Богд хаант монгол улсын үед, Монгол зураачид энэ зохиолын үйл явдал бүхэнд маш сайхан зураг зурж тайлбарын хамт хэвлэн гаргажээ. Бас Бэнсэн үлгэрч нарын уншдаг зохиолын нэг байсан ба Богдын ордон, Чойжин ламын сүмийн хаалга, туурганд зурсан нь үлэмж.

Сүн улсын «Хүйтэн уулын бичгийн тухай академич Б. Ринчен гуай «XIX зууны сүүл үеэс XX зууны арван есдүгээр он хүртэл нэгэн хэсэг дэвшилт сэхээтэн хятад хэлнээс нэлээд хэдэн алдарт бичиг орчуулсан. Түүний дотор «Хүйтэн уулын бичиг» гэгчийг орчуулсан нь «Дөрвөн нэрт бичиг» гэдэг түүний орчуулгатай нийлж монгол хэлэнд бүрэн болгосноор барахгүй, тэр «Хүйтэн уулын бичиг» гэдгийг орчуулж эхэлсэн үе нь яг. Манж Дайчин улсын Бадаргуулт төр хааны үед, Ар Монгол газар, ард түмэн манж дарлагч нарыг маш жигшин энд тэнд эсэргүүцэл хөдөлгөөн гарч байсан үе. Эрт дээр ХШ зууны Сүн улсын цагт дарлагдсан тариачин ардын маш их хөдөлгөөн гарсныг өгүүлсэн. Тэр бичгийг тийнхүү орчуулсан нь хянавал дотроо бас учиртай бөгөөд одоо сая тэр романыг орос хэлэнд орчуулж, англи хэлэнд Парл Пак гэдэг хүн орчуулж 1933 онд сая хэвлэн гаргаснаас түрүүлж, монгол уншигч нар гар бичмэлээр олж уншин бахархаж байсан нь манж харгис засгийг эсэргүүцэх сэтгэлд нь галд тос нэмсэнтэй адил байсныг юун өгүүлтэл!» гэж бичсэн буй. XX зуун гарахад 1909 онд «Хүйтэн уулын бичгийг» дахин хөрвүүлж, «Жинь Пинь Мэй» романыг 1914 онд М. Цэрэндорж (манай төрийн нэрт зүтгэлтэн, хичээнгүй сайд болсон хятад манж хэлийг нэвтэрхий сайн мэддэг хүн) гүн Балданцэрэн, Цэдэвсүрэн, Ядмаа, Даваа зэрэг хүмүүс орчуулсан.

Наймдугаар богд Жавзандамба (1870-1924) Ван овогт Элбэгбат зэрэг хүнээр тусгайлан нангиадаас уран зохиолын бүтээл орчуулуулж, номынхоо санд тэр орчуулгыг нь сийрүүлэн, шар торгоор хацарлуулж хадгалуулаад сайхан уншдаг хүнээр тэдгээр уран зохиолыг уншуулан сонсдог байсан. Бас номд дуртайгийг нь мэдэх тэр үеийн бичгийн хүмүүс манж зэрэг хэлнээс орчуулан өргөж байсан зүйл ч байжээ. 1923 онд Бээжин хотноо уран зохиолч Тэмгэт «Меньвень шушэ» гэдэг «Монгол хэл бичгийн номын нийгэмлэг» хэвлэлийн газар байгуулж монгол, төвд, хятад ном бичиг цуглуулж өндөр үнээр худалдан авдаг байлаа. Энэ нийгэмлэгийнхэн «Баруун Хан улсын бичгийг» хэвлэн гаргаж, 28 онд Тэмээт «3 улсын түүхийн» шинэ орчуулга хийн, номын газар, ус, хүмүүсийн нэрсийг тодорхой бус орчуулж байжээ гэж бичсэн байдаг. Тус хэвлэлийн газар 1916 онд Пү Сүнлиний «Ляо жай жи и бичиг»-ийг хэвлэн гаргажээ.

1959 онд монгол бичгийн чуулган цуврал бичгийн 11 дүгээр ботид Б. Ринчен багш «Эрт эдүгээгийн гайхамшигт сайхан үзэгдэл хэмээх судар» (Дээд дэвтэр) гэдэг хятад үлгэрийг монгол бичгээр нийтэлсэн. Дээд дэвтэрт 40 үлгэр орсон бөгөөд 12 дугаар ботид орох байсан бусад үлгэрүүд гараагүй. Уг зохиолыг монгол хэлнээ хэдэнтээ орчуулсан. 1959 оны хэвлэлийн эх бичиг нь улсын нийтийн номын санд хадгалж байгаа хятад цаасан дээр сударчилсан, бийрээр бичсэн 3 боть зохиол болно. 1969 онд Б. Содном гуай Хэ Ван Юаны бичиг зохиолыг хэвлүүлсэн. Энэхүү зохиолын үйл явдал нь эртний хүн улс, хан улсын үед болсон явдлаас сэдэвлэн бичсэн. Ван Чиан хэмээх ордны хатны бичсэн энэ зохиолыг 1917 онд Чин Сүжигт номын хан хутагт Цэдэнбалжирын даалгавраар Харчины Мөнхтогтох чансан монгол хэлнээ хөрвүүлжээ. Энэ хүн нэг дор хэд хэдэн номыг зэрэг орчуулдаг, олон хэл мэддэг хүн байсан бөгөөд сайн ноён хаан Намнансүрэн, Чин сүжигт номын хан Цэдэнбалжир хутагт нарын багш байсан.

Хятад романы (туурил, бичиг) орчуулгыг судалсан түүхийг цухас дурдвал:

Өрнө дахинд, өнгөрсөн зууны сүүл үеэс германы нэрт нанхиадач Вильгельм Грубе «Фань Тань Яньи» гэдэг туурил (романы) -ийн монгол орчуулгыг олж мэдээд нийтэлснээр, энэ талын судалгааны тулгын чулууг тавьсан бөгөөд Э. Хэниш, ХБНГУ-ын Хайссиг, Шольц нар үргэжлүүлсэн. Ялангуяа Э. Хайссиг гуай «Герман улс дахь дорно дахин бичмэлийн гарчиг», «Монголын утга зохиол» гэдэг номдоо монгол орчуулгын тухай тун чамбайхан тодорхойлолт үйлджээ. Зөвлөлтийн нэрт монголч Владимирцов гуай энэ талаар өгүүлсэн нь бий бөгөөд, зөвлөлтийн эрдэмтэн Михайлов гуай «Монголын уран зохиолын түүхийн өгүүллүүд». Б. Л. Рифгин доктор, П. А. Семанов гуай нар «Хятад сонгодог романы монгол орчуулга» гэсэн судалгааны өгүүлэлдээ эл сэдвийн талаар тун дэлгэрэнгүй сайхан бичсэн билээ. Дэлхийн олон улс орны номын сан хөмрөг дэх хятад сонгодог романы монгол орчуулгын гарчгийг нийт монгол бичмэл, дармал номын нэрст оруулан гаргаж байгаа ч (Боудэн, Владимирцов, Пучковский, Фаркухар нарын гаргасан гарчгийн тухай Б. Ринчен гуайн «Монгол бичгийн хэлний зүй» номын I дэвтэр 202— 209 талд үз!) Рифтин, Семанов нарын бичсэнээр ЗХУ, БНХАУ-д энэ ажил дөнгөж эхэлж буй ажээ. Манайд Д. Жадамбаа гуай, 1960 онд улсын нийтийн номын сангийн бичмэл уран зохиолын номын гарчгийг үйлдэж, «Студиа Монголика» гэдэг цувралын тэргүүн ботид нийтлүүлсэн. Нийтдээ хятадын үргэлжилсэн үгийн том хэмжээний 70 гаруй зохиолын монгол орчуулга бий гэж Рифтин, Семанов нарын судалгааны өгүүлэлд бичжээ. Тэд дээрх романуудыг сэдэв агуулгаар нь: — ажил байдлын хийгээд хайр сэтгэлийн роман; түүхэн болон туульсын том хэмжээний зохиол; гайхам зүйлсийг зөгнөлт хэлбэрээр бичсэн роман; дээрэмчдийн адал явдал мөн элдэв хэргийг шүүсэн тухай роман; шог хошин зохиол тэж ангилсан.

Харин япон, манж, вьетнамд 30 орчим зохиол орчуулсан байна. Ийнхүү Чин улсын үеийн Хятад оронд ардчилсан агуулгатай дээрх зохиолыг хориглон хааж, Күнзийн сургаалыг тархааж байсан тэр үед монгол дуун хөрвүүлэгч нар ард түмэндээ хятадын шилдэг уран зохиолтой танилцах завшаан олгожээ. Орчуулгын найруулга үг хэллэг нь тансаг сайхан монгол хэлний үгсийн сангийн агуу нөөцийг илрүүлэн гаргахад тус дөхөм үзүүлсэн гэж үздэг болой.